



Бурхан бол Бүтээгч Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Бүтээгч

Attribute: God Is the Creator

Тодорхойлолт: Орчлонг бүтээж түүн доторх бүх юмс болоод тэдгээрт амийг бий болгосон Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Эхлэл 1:1** Эхэнд Бурхан тэнгэр ба газрыг бүтээжээ.
- **Дуулал 148:1-6** Эзэнийг магтагтун! Тэнгэрсээс ЭЗЭНийг магтагтун! Түүнийг өндөрт магтагтун! Түүний бүх тэнгэр элч нараа, Түүнийг магтагтун! Түүний хамаг түг түмд, Түүнийг магтагтун! Нар ба сараа, Түүнийг магтагтун! Гэрэлт бүх од оо, Түүнийг магтагтун! Тэнгэрсийн тэнгэр ээ, Тэнгэрийн дээрх ус аа, Түүнийг магтагтун! Түүний тушааснаар тэд бүтээгдсэн тул. Тэднээр ЭЗЭНий нэрийг магтуул. Бас үүрд мөнхөд тэднийг байрлуулж, Хэзээ ч өнгөрөн одохгүй зарлигийг Тэр гаргажээ.
- **Иохан 1:3** Бүх юм Түүгээр буй болсон. Буй болсон юмсаас Түүнгүйгээр буй болсон юмс гэж нэг ч үгүй.
- **Колоссай 1:16** Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дуулал 100:3

Библийн эшлэлээр залбирах:

ЭЗЭН болбоос Бурхан гэдгийг (Хүүхдийн нэр) мэдтүгэй! (Хүүхдийн нэр)—г бүтээсэн нь Тэр бөгөөд (Хүүхдийн нэр) Түүний ард түмэн, Түүний бэлчээрийн хонин сүрэг мөн.

Залбирлын тодорхой хүсэлт

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- ЭЗЭН болбоос Бурхан гэдгийг _____ мэдтүгэй! _____—г бүтээсэн нь Тэр бөгөөд _____ Түүний ард түмэн, Түүний бэлчээрийн хонин сүрэг мөн. *Дуулал 100:3*

Сургуулийн төлөө залбирах — Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!